

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТ
(Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газар)

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1	эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	Эрүүл мэндийн газар www.health.bo.gov.mn цахим хуудсыг тогтмол ажиллуулж байна. Тус цахим хуудаст байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилтууд, бусад мэдээллийг байрлуулсан. Эрүүл мэндийн газрын бүтэц, зохион байгуулалтын дагуу ажилчдын овог нэр, албан тушаал, зургыг хэлтэс тус бүрээр байрлуулж, хийгдэж байгаа үйл ажиллагааны талаар ил тод байдлыг хангаж, мэдээ, мэдээлэл тогтмол байршуулан ажиллаж байна. Үүнд хүний нөөцийн ил тод байдал, санхүүгийн ил тод байдал, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой мэдээлэл, статистик мэдээлэл, байгууллагын баримтлан ажиллах дүрэм журмууд зэрэг байна.	90%
1.2	чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг	Төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд түргэн шуурхай хүргэх зорилгоор ажлын байрны зорилго, зорилт, үндсэн чиг үүрэг, байгууллагын хаяг, байршил, бүтцийн танилцуулга, өргөдөл гомдол хүлээж авах ажил хариуцсан албан тушаалтны овог нэр, утасны дугаар зэргийг www.health.bo.gov.mn цахим хуудсанд олон нийтэд ил тод байрлуулсан. Байгууллагын FB хуудас болох Баян-Өлгий Эрүүл Мэндийн Газар нийгмийн сүлжээнд байгууллагын хаяг, холбоо барих 70722511 дугаартай утасны мэдээллийг оруулсан. Үүнээс гадна дээрх мэдээллүүдийг байгууллагын үүдэнд байрлах мэдээллийн самбарт нээлттэй байрлуулж, ирсэн санал өргөдөл гомдлыг цаг тухайд нь шийдэврлэж хариу өгч ажиллаж байна.	100%
1.3	эдийн засаг, нийгмийн хөгжилийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн, үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж	Харьяа сумдын эрүүл мэндийн төвийг мэргэжил, арга зүйгээр хангах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор дэмжлэгт хяналт үнэлгээ хийж, санхүүгийн үйл ажиллагаанд нь мөрдөн ажиллах зарим эрх зүйн актуудыг танилцуулан, зөвлөмж хүргүүлэн ажиллав. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 05 тоот тогтоолын 3 дугаар зүйлийн 3.12 дахь заалтын дагуу “Сум, тосгоны эрүүл мэндийн төв”-д ажиллах хүний нөөцийн доод хязгаарыг батлах тухай” газрын даргын А/51 дүгээр тушаалын биелэлтэд хяналт тавьж, одоо ажиллаж байгаа болон ажиллах ёстой ажилчдын судалгааг гаргаж мэргэжил арга зүйгээр хангаж ажиллав. Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2018 оны 382, 2019 оны 05, 33, 2023 оны 240, 241 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/548 тоот тушаал, 2019 оны 611 тоот тушаал, стандарт зэрэг холбогдох эрх зүйн актуудыг мөрдөн ажиллаж, төсвийн сахилга батыг чанд сахиж, батлагдсан орон тооны дэд хязгаарт багтаан, тэтгэвэрт гарсан хүний оронд шинээр хүн нэмж авахгүй байж, тэвчиж болох зардлуудаа хэмнэн төлөвлөгөө боловсруулан ажиллахыг зөвлөн ажилласан. Эрүүл мэндийн яамнаас ирсэн чиглэлийн дагуу харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, өгсөн акт, албан	90%

шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт үнэлгээ хийж, аудитаар илэрсэн зөрчлийг хуулийн хугацаанд багтааж арилгах, давтан гаргахгүй байж, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг мөрдөн ажиллаж, хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган, төсвийн сахилга батыг чанд сахиж, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.9 дэх заалтыг мөрдөж, батлагдсан орон тооны дэд хязгаарт багтаан, тэвчиж болох зардлуудаа хэмнэн дээрх алдаа дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан ажиллахыг анхааруулж ажиллав.

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 3 төрлийн зөвлөмж өгсөн.Үүнд:

1. ЭМЯамнаас батлагдсан орон тооны хязгаарыг 39 хүнээр баталсан боловч гүйцэтгэлээр 41 орон тоо ажиллуулсан байна. Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.3-д “бүх шатны Засаг дарга эрүүл мэнд ийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн харьяалах нутаг дэвсгэрийнхээ эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, оновчтой байршуулах, материаллаг бааз, хүний нөөцийн болон санхүүгийн нөөцийг зохистой хуваарилах” гэсэн заалт, Эрүүл мэндийн сайдын 415 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтэц үйл ажиллагааны чиглэлийг батлах тухай” журмыг мөрдөж орон тооны хязгаарыг хэтрүүлсэн зөрчил давтагдан гарч байгаа асуудалд дүгнэлт хийж, төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг үндэслэлтэй хийж, илэрсэн зөрчлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авах гэсэн зөвлөмжийн хүрээнд:
 - Аймгийн Засаг даргын тамгын газарт 2021 оны 7 дугаар сар , 2023 оны 2 дугаар сард Эрүүл мэндийн газрын бүтэц орон тоог Эрүүл мэндийн яам болон Сангийн яамнаас баталж өгсөн тухайн онуудын цалингийн сан, орон тооны дагуу ажлын ачаалал, гүйцэтгэх чиг үүргийн давхардал, төрийн захиргааны байгууллагын шалгуур зэргийг харгалзан үзэж шаардлагатай орон тоог батлуулах хүсэлт өгсөн.
 - 2019 оны Засаг даргын захирамжаар батлагдсан бүтэц, орон тоонд яамнаас баталж өгсөн 39 орон тоонд 44 хүн ажиллахаар баталсан . Үүнээс гадна бусдаар гүйцэтгүүлэх ажлын мөнгийг гэрээт 4 манаачид олгосон ба нийт 48 орон тоогоор цалинжиж байсан.
 - Уг нь бусдаар гүйцэтгүүлэх ажлын хөлсийг Сангийн сайдын тушаалд зааснаар хараат бус ёс зүйн хороо, эмнэлэг, эмийн сангуудад тусгай зөвшөөрлийн ажлын хэсгийн шинжээч нарын болон гэрээт өмгөөлөгчийн ажлын хөлс зэрэгт зарцуулах ёстой байтал бид 4 гэрээт манаачийг цалинжуулж, тэдгээр хүмүүсийн хөлс олгогдохгүй байгаа. Бидний боловсруулсан шинэ орон тооны бүтцийн төсөлд 4 манаачийг үндсэн орон

тоонд багтаасан болно.

- 2022 оноос эхлэн тэтгэвэрт гарсан болон ажлаас халагдсан хүмүүсийн оронд нь шинээр хүн авч ажиллуулаагүй, ижил мэргэжлийн ажил эрхэлж буй ажилчдын ажлын ачааллыг харгалзан үзэж ямар нэгэн ажил хавсран гүцэтгэсний нэмэгдэлгүйгээр хариуцуулсан. 2023 онд Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбоотой 5 байцаагч нэмэгдэж 47 орон тоогоор ажиллаж байгаа ба 2 орон тоогоор илүү байгаа. Энэ нь цаанаа бүх ажилчин мэргэжилтнүүд ажлын байрны шаардлагад нийцэж байгаа гэсэн үг биш, огт ажлын байрны шаардлага, Төрийн албаны хууль тогтоомжинд нийцээгүй. Эрүүл мэндийн газрын гүйцэтгэх ажлын чиглэлд таарч тохирохгүй 4 орон тоонд шинээр ажлын шаардлагаар нэмэгдэх 4 орон тоо байгааг мэргэжлийн байгууллагын хувьд боловсруулан хүргүүлсэн боловч одоо хүртэл батлагдаагүй байгаа.

2. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хүүлийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэсэн зөвлөмжийн хүрээнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хүүлийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хүүлийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэсэн заалтыг мөрдөж, эзлэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох

		<ul style="list-style-type: none"> - Байгууллагын дэргэдэх өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдийн саналаар ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах боломжгүй 79,9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах санал явуулж, ИТХ-ын 2023 оны 156 тогтоолоор 79,9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах шийдвэр гарсан. Мөн ИТХ-ын 155 тогтоолоор 30,5 сая төгрөгийн автомашиыг Орон нутгийн өмчийн газарт төвлөрүүлсэн. ИТХ-ын 159-р тогтоолоор 3,5 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн. - Мөн өмч хамгаалах байнгын зөвлөлийн саналаар анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн , цаашид ашиглах боломжтой 50,2 сая төгрөгийн хөрөнгийг 22,5 сая төгрөгөөр дахин үнэлж , 47,8 сая төгрөгийн актлах хөрөнгийн жагсаалтыг орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн. Эрхийн акт нь хараахан гараагүй байна. <p>3.Аймгийн Эрүүл мэндийн газар нь "Ниссан патрол", Пургон, Хантер маркийн бүгд 3 суудлын авто машин ашиглаж байна Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3, 6.5 дахь заалт, Засгийн газрын 2022 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”-ын 204 дүгээр тогтоолын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллах зөвлөмжийн хүрээнд:</p> <p>Байгууллагын данс бүртгэлд байгаа 3 автомашиныг аймгийн орон нутгийн өмчийн газарт татан төвлөрүүлэхтэй холбоотой аймгийн ИТХ-ын хуралдааны 155 тогтоол гарсан. Манай байгууллага салбар нэгж ихтэй, чиг үүргийн хувьд өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал,</p> <ul style="list-style-type: none"> - Харьяа сумын ЭМТөвүүдэд хяналт үнэлгээ хийж мэргэжил арга зүйгээр хангах - Аймгийн хэмжээнд хоолны хордлого, хордлогот халдвар бүртгэгдсэн тохиолдолд голомтын тандалт судалгаа хийх, дээж цуглуулах, сэжигтэй бүртгээгдэхүүнийг тогтоох - Байгалийн гамшиг болох зуд, газар хөдлөлтийн үед харьяа эрүүл мэндийн байгууллагуудыг шуурхай удирдлагаар хангах - 2023 оныд МХГазрын эрүүл мэндийн улсын байцаагч нар тус газарт шилжиж ирсэнтэй холбоотой төрийн хяналт шалгалтыг давхар гүйцэтгэж байна болно. Иймээс, 30,753,772 төгрөгийн УАЗ Фургон автомашиныг орон нутгийн өмчийн газарт төвлөрүүлж, 2 автомашиныг авч үлдсэн болно. 	
1.4	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын 3 дугаар хавсралын хүснэгт 3.10 болон аймгийн Засаг даргын 2021 оны А/751 дүгээр захирамжаар батлагдсан журмын 9 дүгээр	80%

		хавсралтын дагуу байгууллагын тайланг үнэлж, холбогдох тайлангийн хамт Эрүүл мэндийн яам, аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн.	
1.5	хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг гаргаж, заасан хугацаанд Эрүүл мэндийн яам, аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн.	80%
1.6	үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг жилийн эхний хагаст хагас жилийн байдлаар, сүүлийн хагаст сар бүр гаргаж, Эрүүл мэндийн яам, аймгийн ЗДТГ-т хүргүүлж байна.	80%
1.7	албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар албаны цахим шуудангийн хаяг	Эрүүл мэндийн газрын бүтэц, зохион байгуулалтын дагуу ажилчдын овог нэр, албан тушаал, цахим шуудангийн хаяг зургыг хэлтэс тус бүрээр байрлуулж, ажиллаж байгаа хүний нөөцийн ил тод байдлыг хангасан. Өрөө болгонд албаны хариуцах утас байхгүй, зөвхөн даргын туслах албаны суурин утастай. Утасны дугаарыг байгууллагын цахим хуудасны нүүр хэсэг болон холбоо барих буланд байршуулсан.	90%
1.8.	өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээ	Тайлант хугацаанд байгууллагад 145 өргөдөл ирсэнээс 30 хувь нь байгууллагын албан хаагчаас ирүүлсэн байна. Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 12 хоног байна. Тайлант хугацаанд нийт шийдвэрлэсэн өргөдөл, гомдлоос тодорхойгүй шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг тухай бүр нь бүртгэн авч, Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэр тал дээр анхааран холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажилласан. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд сахилагын ийтгэл ногуулах тухай саналыг салбар нэгжүүдэд уламжлан ажилласан. Тайланг улирал тутам гарган холбогдох газарт хүргүүлсэн. Аймгийн нэгдсэн эмнэлгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албанд үйлчлүүлэгчид болон эмнэлгийн ажилтнуудаас ирсэн өргөдөл, гомдол, саналыг "Тусламж үйлчилгээний талаар гаргасан өргөдөл, гомдол, саналыг шийдвэрлэх тухай журмын дагуу бүртгэж, шийдвэрлэж ажилласан.	100%
1.9	хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	Байгууллагын health.bo.gov.mn цахим хуудсын статистик мэдээ буланд аймгийн эрүүл мэндийн салбарын улирал бүрийн статистик мэдээллийг байрлуулдаг.	100%
1.10	мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	Үгүй.	
Хэсгийн дундаж хувь: 82%			

Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
2.1.	ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	<p>“Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоог нөхөх, тусгай шалгалт зарлуулах тухай захиалгыг” аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 3 удаа хүргүүлэн 4 ажлын байранд тусгай шалгалтыг зарлуулсан. “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын дагуу тухайн албан тушаалд ажиллах тусгай шаардлагыг ханган, аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсэн 4 иргэнийг Газрын даргын 2023 оны Б/05, Б/06, Б/07 дугаар тушаалуудаар төрийн жинхэнэ албанд томилон ажиллуулж байна.</p> <p>Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журмын дагуу 3 албан хаагчтай тус тус харилцан тохиролцож Газрын даргын тушаалаар албан үүргийг түр орлон гүйцэтгүүлсэн.</p> <p>Тайлант хугацаанд мөн “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ын дагуу нөөцөд бүртгэгдсэн 2 иргэнийг төрийн захиргааны албан тушаалд ажиллуулж байна.</p>	100%
2.2.	албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам	<p>“Төрийн албаны тухай хууль” болон төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тухай мэдээллийг байгууллагын вэб хуудас, фэйсбүүк хуудсуудад тус тус 3 удаа байршуулж, олон нийтэд мэдээлсэн. Ажилгүй байгаа эмч, мэргэжилтнүүдийг тухай бүр бүртгэн авч хувийн хэвшлийн болон өрх, сумын эмтөвөөс гарсан түр орон тоог санал болгон ажиллаж байгаа. Нэгдсэн эмнэлгийн хувьд ажилд орохыг хүссэн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтанг Эмнэлгийн Ерөнхий эмчийн 2021 оны А/31 дүгээр тушаалаар батлагдсан “Сонгон шалгаруулах журам”-ын дагуу Удирдлагын зөвлөлийн хурал болон тасгийн хамт олны хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр ил тод, нээлттэйгээр сонгон шалгаруулан томилгоо хийж ажилласан. 2023 онд үндсэн болон түр ажлын байраар хангагдсан 65 гаруй ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан.</p>	100%
2.3.	албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	<p>Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны А/03 дугаар тушаалаар байгууллагын дэргэдэх “Ёс зүйн зөвлөл”-ийг байгуулан ажиллах журам”-ыг баталсан.</p> <p>“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хууль шинэчлэн батлагдсантай холбоотой албан хаагчдыг сургалтад Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтад 2 удаа хамруулан ажилласан. 2023 онд ЭМГазрын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос Эрүүл мэндийн сайдын 2019 оны 406 тоот тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ”-г цахим хуудсанд байршуулан, харьяа эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний хэсгийн хороо, ёс зүйн багууд дээрх тогтоол шийдвэрүүдийг үйл ажиллагаанд хэрэгжүүлэн Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/256 тоот тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хорооны дүрэм” болон маягтын дагуу үйл ажиллагааны тайлагнадаг болсон.</p>	100%

		<p>Байгууллага бүрт “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ”-ний самбар ажиллуулдаг ба албан хаагчдын ёс зүйн дүрмийг мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулсан.</p> <p>Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил гарган, хууль хяналтын байгууллагуудын хяналт шалгалтаар тогтоогдсон 3 эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг ЭМС-ын тушаалаар 3 сараас 1 жил хүртэлх хугацаагаар түдгэлзүүсэн</p> <p>"Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй" сэдэвт сургалтыг эрүүл мэндийн яамны дэргэдэх "эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо"-ноос 1 удаа , Эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж байгаа ёс зүйн зөвлөл, эмнэлгийн мэргэжилтний хэсгийн хороо, ёс зүйн багууд төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх зорилгоор цахим сургалт, дотоод сургалтыг тогтмол зохион байгуулж ажилласан.</p>	
2.4.	хүний нөөцийн стратеги, түүнийг хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	<p>Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах, тогтвор суурьшилтай ажиллуулж, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хууль, хуулийг дагалдан гарсан дүрэм, журмын дагуу одоо ажиллаж байгаа албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, сул орон тоог байгууллагын дотор болон харьяа байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас шатлан дэвшүүлэх эсхүл нөөцөд байгаа төрийн албан хаагчдаас нөхөх бодлого, чиглэлийг баримтлан ажиллаж байна. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг байгууллагын цахим хуудсандаа байрлуулсан тухай бүр шинэчлэн ажиллаж байна. 2023-2024 оны хичээлийн жилд төсвийн зардал болон орон нутгийн зардлаар суралцах эмч, мэргэжилтнүүдийн захиалгыг салбар нэгжүүдээс авч хүний нөөцийн төлөвлөгөөний дагуу сургалтын захиалгыг хийж Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан суралцагчдын хяналтын тоо, бусад мэдээллийг салбар нэгжүүдэд хүргүүлэн, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.</p> <p>Хүний нөөцийн одоогийн байдалд дүн шинжилгээ хийж мэргэжилтнүүдийн мэргэшсэн байдлын судалгааг гаргасан. Үүнд: сум , тосгон ,өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт ажиллаж байгаа 80 их эмчийн 54% буюу 43 , 135 сувилагчийн 30% буюу 42 сувилагч төгсөлтийн дараах мэргэшил олгох, дээшлүүлэх сургалтанд хамрагдсан бол Нэгдсэн эмнэлэгт ажиллаж байгаа эмч нарын 97 буюу 90,5%, сувилагчдын 75 буюу 48 % нь нарийн мэргэжилийн сургалтанд хамрагдсан тухай судалгаа гарсан. Цаашид төгсөлтийн дараах сургалтад анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг түлхүү хамруулах, НЭ-ийн сувилагч, тусгай мэргэжилтнүүдийг үе шаттай мэргэшүүлэх сургалтад хамруулах шаардлагатай байна.</p>	100%
2.5.	хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	<p>Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар газрын Эрүүл мэндийн газар www.health.bo.gov.mn цахим хуудсанд ойлгомжтой байдлаар байршуулан баяжилтыг тухай бүр хийж байна.</p>	80%

2.6.	албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам	<p>Ажилтнуудын ажлын үр дүнг үнэлэх ажлыг журамд заасан хугацаанд зохион байгуулж холбогдох журмын дагуу албан хаагчдад үр дүнгийн урамшуулал болон улирлын урамшууллыг олгож байна.</p> <p>Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, 2019 оны 395 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн газрын төрийн үйлчилгээний албан хаагч, Нэгдсэн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төвийн дарга нарын ажлыг сар бүр шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж ажлын үр дүнгээр урамшуулал олгогдсон .</p> <p>Нэгдсэн эмнэлгийн хувд “Эрүүл мэндийн ажилтанд улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшуулал” олгох тухай 05 дугаар Тогтоолын дагуу эмч ажилчдын мэргэжлийн ур чадвар, ажлын гүйцэтгэлийг үнэлэх журамтай. Тасаг бүр ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг тусгай шалгуур үзүүлэлтээр хүн тус бүрээр дүгнэн саналаа удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлж албан хаагчдын ажлын үр дүнгээр үр дүнгийн урамшуулал олгодог.</p>	100%
Хэсгийн дундаж хувь: 96,6%			
Гурав. Төсөв, санхүү, худалдан авах үйл ажиллагааны талаарх			
3.1.	өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл	Эрүүл мэндийн газар нь 2021 онд 2,556,460,200 төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, 2,553,475,128 төгрөгийн буюу 99,5%-ийн гүйцэтгэлтэй гарсан. 2022 оны 3,098,490,000 төгрөгийн батлагдсан төсөвтэй. Үүний 2,332,412,800 төгрөг нь салбарын хэмжээний Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 ба 29.5 дахь заалтуудаар авах тэтгэмжийн мөнгө болно. 2023 оны төсвийн төслийш боловсруулж Эрүүл мэндийн яаманд уламжилсан. Шилэн дансанд тухай бүрт нь мэдээлсэн.	100%
3.2.	төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	Эрүүл мэндийн газар нь 2022 оны хагас жилийн байдлаар 1,306,883,600 төгрөгийн батлагдсан төсвөөс 1,220,847,719 төгрөгийн буюу 93,4%-ийн гүйцэтгэлтэй гарсан. Эрчим хүчний зохицуулах хорооноос 1м3 халаалтын үнийн тариф шинэчлэн баталсантай холбоотой түлш, халаалтын зардлаас 2,279,412 төгрөгийн өртэй гарсан. 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланг pdf файл хэлбэрээр шилэн дансанд байршуулсан. 2022 оны бүтэн жилийн санхүүгийн тайлан гарах хуулийн хугацаа болоогүй байгаа.	100%
3.3.	санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	Аймгийн Төрийн аудитын газраас 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, зөрчилгүй санал дүгнэлт авсан. Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь шилэн дансанд хуулийн хугацаанд байршуулсан.	100%
3.4.	хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	үгүй	-

3.5.	төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг Эрүүл мэндийн яаманд хүргүүлдэг. Мөн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээний хэтрэлт, хэмнэлтийн тайлбарын хамт шилэн дансанд байршуулдаг.	100%
3.6.	таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг	үгүй	-
3.7.	цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	Эрүүл мэндийн газрын 100020020001, 100020020401 тоот дансуудад 5,000,000 төгрөгөөс дээш орсон орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт сар болгон шилэн дансанд байршуулдаг. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 2,217,076,650 төгрөгний орлогын, 1,056,378,458 төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд байршуулсан болно.	100%
3.8.	бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүссэн аливаа шийдвэр	2022 оны 02-р сард 3 төрлийн , 4-р сард 4 төрлийн , 5-р сард 2 төрлийн , 6-р сард 2 төрлийн , 7-р сард 2 төрлийн , 9-р сард 1 төрлийн, 10-р сард 2 төрлийн нийт 16 төрлийн байгууллагын даргын хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой тушаалуудыг pdf файл хэлбэрээр шилэн дансанд байршуулсан.	100%
3.9.	шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	<p>- Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын шилэн дансны хөтлөлтөд буюу цаг тухайд нь хууль журмын дагуу байршуулсан эсэхт байнга хяналт тавьж ажиллаж байна. Энэ жилийн байдлаар 100% хөтөлөн ажиллаж байгаа боловч хуцаа хоцроосон алдаа дутагдал илэрсээр байна. Цаашид хугацаандаа оруулж хэвших талаар албан бичиг хүргүүлэн арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Мөн эрүүл мэндийн байгууллагуудын шилэн дансны хэвийн үйл ажиллагааг хангуулах зорилгоор сар болгоны эхэнд харьяа эрүүл мэндийн байгууллагуудын нягтлан нарт утсаар болон цахимаар сануулан, албан бичгээр шилэн данс хөтлөх талаарх заавар зөвлөмж өгч ажилладаг.</p> <p>- Эрүүл мэндийн яамны 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 2/3030 дугаар албан тоотын дагуу манай харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт, шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, түүний хавсралт болон дэд цэсүүдэд тавигдсан мэдээлэл, түүний агуулга олон нийтэд ойлгомжтой байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, гарсан алдаа дутагдалын талаар Эрүүл мэндийн газрын даргын 553 тоот албан бичгээр зөвлөмж өгч, арга зүйгээр ханган ажилласан. Аудитын байгууллагаас өгсөн акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг цаг тухайд нь хэрэгжүүлж, цаашид зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж, төлөвлөгөө</p>	100%

		гаган ажиллахыг үүрэг болгож ажиллав.	
3.10.	төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагуудын хэрэгцээт эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн дагуу төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр зохион байгуулсан. Гүйцэтгэлийг сонгон шалгаруулахдаа багц тус бүрээр Сангийн сайдын 2012 оны 194 дүгээр тушаалаар баталсан жишиг баримтын 35 дахь заалтын дагуу хүчинтэй байх хугацаанд үнэлэн шалгаруулж, хууль тогтоомжийн дагуу ил тод байдлыг ханган ажилласан. Уг ажлын хэрэгжилтийг хангах зорилгоор тендер шалгаруулалтын урилга, үр дүн, тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэж, тендерт шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тендерт оролцсон компаниудад албан бичгээр мэдэгдэж, эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээг харьяа эрүүл мэндийн байгууллагуудын дарга нараар захиалагч, нийлүүлэгчийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулав	100%
3.11.	худалдан авах үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт	Аймгийн Төрийн аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудитын хяналтад "Төрөөс эмийн талаар баримтлах бодлого"-ыг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, "Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль", "Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, түгээлтэд тавих шаардлага"-ыг хэрэгжүүлсэн тайлан болон бусад холбогдох баримт материалыг хүргүүлсэн. Хяналт үнэлгээгээр гарсан зөрчил дутагдлыг арилгах зөвлөмжийн дагуу Эм, эмнэлгийн хэрэгслийн тендер шалгаруулалт, Эргэлтийн эмийн сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллав. Уг ажлыг хэрэгжүүлснээр хүн амыг эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, түгээх тогтолцоо бүрдэж байна.	100%
3.12.	мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил аргазүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл	үгүй	-
3.13.	төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн	2023 оны тайлант жилд 14,607,300 төгрөгийн төсөл, хөтөлбөрийн санхүүжилттэй. Гүйцэтгэл нь 7,187,390 төгрөг.	70%
3.14.	мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил,	үгүй	-

	түүний тайлан		
3.15.	хууль тогтоомжид заасан бусад	<p>Эрүүл мэндийн салбартай холбоотой, нийтэд мэдээлэх зайлшгүй шаардлагатай мэдээллүүдийг тухай бүрт байгууллагын цахим хуудас, Facebook пэйж хуудас, мэдээллийн самбараар дамжуулан мэдээлж байна. Цахим хуудасны “Эрхзүйн актууд” буланд холбогдох хууль тогтоомж, аймагт хэрэгжиж байгаа дэд хөтөлбөрүүд, “Ил тод” булангаар байгууллагын шилэн дансыг тогтмол хөтөлж, санхүүгийн ил тод байдлын тайланг тухай бүрт байршуулдаг.</p> <p>Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын шилэн дансны хөтлөлтийг цаг тухайд нь хууль журмын дагуу байршуулсан эсэхт байнга хяналт тавьж ажиллаж байна. ЭМЯ-ны санхүүжилттэй эрүүл мэндийн 6 байгууллагын шилэн дансны мэдээлэлд хяналт тавьж, удаа дараа шаардаж бүрэн байршуулж,тайланг нэгтгэн ЭМЯ-нд хүргүүлж байна.</p>	-

Хэсгийн дундаж хувь: 97%

Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн

4.1.	үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл	<p>Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 03-ны А/383 дугаар тушаал болон Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 28-ний А/58 дугаар тушаалаар мөн Улсын мөнгөн тэмдэгтийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн дагуу үйлчилгээ үзүүлж байна. Мэдээ мэдээллэл аймгийн эрүүл мэндийн газрын цахим вэб хуудсанд ил тод байгаа болно.</p>	100%
4.2.	тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа	<p>Эрүүл мэндийн сайдын А/383 тушаал, аймгийн Эрүүл мэндийн газрын даргын А/58 тушаалуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс 5 хүний бүрэлдэхүүнтэй.</p> <p>Тусгай зөвшөөрлийн комисс нь 9 удаа хуралдаж, комиссын шийдвэрээр 3 клиник, 4 эмийн санд тус бүр 5 жилээр шинээр тусгай зөвшөөрөл олгож, 3 ортой эмнэлэг, 6 клиник, 4 ӨЭМТ, 4 СЭМТ, 1 тосгоны ЭМТ, 2 ТТЭМТ, 2 АХШМХХК, 21 эмийн сан, нийт 50 эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 9 ЭМБ-ын тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулж, 4 эмийн сангийн ТЗ-ийн эрхийг хүчингүй болгож, 8 эмийн сангийн ТЗ-ийн эрхийг 3 сараар түр түдгэлзүүлж, 6 эмийн сангийн эрхийг сэргээв.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа аймгийн Эрүүл мэндийн газрын цахим вэб хуудсанд ил тод тухай бүрт мэдээллэж байгаа.</p>	100%

Хэсгийн дундаж хувь: 100%

Тав. Бусад мэдээллийн ил тод нээлттэй байдал			
5.1	олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал	Тусгай зөвшөөрөл хүссэн эрүүл мэндийн байгууллагын орон байр, үйл ажиллагаанд үнэлгээ хийх шинжээч сонгон шалгаруулахаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр намар 1 удаа зар өгсөн боловч хэн ч бүртгэгдээгүй. Нээлттэй зар өгч ёс зүйн салбар хорооны бүрэлдэхүүнийг шинэчилсэн.	90%
5.2	эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт	Үгүй.	
5.3	хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл	Үгүй.	
5.4	мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл	Эрүүл мэндийн газар нь 2009 онд авсан 0210458 дугаартай, Өлгий сумын 4 дүгээр багт төрийн байгууллагын конторын зориулалттай 1500 м.кв талбайтай газрыг 50 жилийн хугацаанд эзэмших гэрчилгээтэй.	100%
5.5	төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг	Үгүй.	
5.6	төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүр: үүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон	Үгүй.	

	шалгаруулалтад оролцогчидын талаарх мэдээлэл		
5.7	төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл	Үгүй.	
5.8	мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл	Үгүй.	
5.9	барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт		
5.10	ашигт малтамалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ	Үгүй.	
5.11	нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлтэй өгөгдөл	Үгүй.	
5.12	мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг \эх\-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн	Үгүй.	

	сургалтын зардал дүн, гэрээний хэрэгжилт		
5.13	хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл	Үгүй.	
Хэсгийн дундаж хувь: 95%			
Хэрэгжилтийн дундаж хувь: 94,1%			

Нэгтгэсэн: ЭМГ-ын НЭМХ-ийн мэргэжилтэн

К.Жандаулет